



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/06

Хөхөө

**Усны холбогдолтой ослоос урьдчилан
сэргийлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд усны ослоос урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: З.Анхсанчир – Засаг даргын орлогч

Гишүүд : М.Буяннэмэх – Хэсгийн төлөөлөгч

Г.Бямбадорж - Цагдаа

П.Оргил – 1-р багийн Засаг дарга

З.Мөнхбат – 2-р багийн Засаг дарга

Н.Эрдэнэбаяр – 3-р багийн Засаг дарга

З.Дашням – 4-р багийн Засаг дарга

Ц.Гансүх – 5-р багийн Засаг дарга

2. Сум орон нутгийн цахим хаягаар мөсний зузаан хөдөлгөөн үйлдэх хэмжээнд хүртэл мөсөн замаар тээвэрлэлт хийхгүй байх талаар сэрэмжлүүлэг, мэдээлэл хийж, хүн ам олноор цуглардаг газруудад анхааруулах хуудас тараан байршуулж, жолооч, иргэдэд гол мөрөн, нуурын мөсөн замын тээвэрлэлт хийхгүй байх талаар баталгаа гаргуулж гарын үсэг зуруулан баримтжуулж авахыг ажлын хэсгийн хэсэг (З.Анхсанчир)-д даалгасугай.

3. Мөсний зузаан хөдөлгөөн үйлдэх хэмжээнд хүртэл сум хооронд, сумаас аймаг хүртэл хөдөлгөөн үйлдэж болзошгүй газруудад хориглох тэмдэглэг, тэмдэглэгээ байршуулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Усны ослоос урьдчилан сэргийлэх, хяналт тавих, үйл ажиллагаа төлөвлөгөө боловсруулан аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2024 оны 02 мэдэгдлийг хэрэгжүүлэн ажиллахыг ажлын хэсэг (З.Анхсанчир)-д даалгасугай.

ДАРГА

A red rectangular official stamp is centered on the page. It contains Mongolian text, including "МОНГОЛ" (Mongolia) at the top and "УСНЫ ОСЛООС СЭРГИЙЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАН АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР" (Mongolian Fire and Disaster Relief Agency) around the perimeter. A large, stylized handwritten signature in black ink is written over the stamp.

Л.ЭНХЖАРГАЛ